


# Хүний нөөцийн хөгжлийн систем – МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ШАЛГАЛТ ГАРЫН АВЛАГА

## Бүртгэл 2025.09.08-д эхлэнэ

http://hr.hdc.gov.mn/

**Бүртгэлтэй хэрэглэгч:**

Хэрэв өмнө нь бүртгүүлсэн бол
“Нэвтрэх нэр”- хэсэгт регистрийн дугаар

“Нууц үг” – Өөрийн бүртгүүлэхдээ үүсгэсэн нууц үгийг оруулах.

**Бүртгүүлэх** товч дарж бүртгүүлэх хуудас руу шилжинэ.

Шинэ хэрэглэгч та **Заавар харах** дарж заавартай танилцана уу /Нэвтэрсний дараа “Тусламж” цэснээс бусад заавартай танилцаарай/

# БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ХУРААНГУЙ ЗААВАР

1. hr.hdc.gov.mn сайтад нэвтэрч “Бүртгүүлэх” дарж бүртгүүлнэ /бүртгэлтэй бол дахин бүртгүүлэхгүй, нууц үгээ сэргээж орно/
2. “Регистрийн дугаар”, “Эцэг эхийн нэр”, “Өөрийн нэр”, “Утасны дугаар”, “И-мэйл хаяг” /и-мэйл хаягаар нууц үг сэргээх, мэдэгдэл илгээх тул алдаагүй зөв бичсэн эсэхээ шалгаарай. YAHOO майл байж болохгүй/, “нууц үг”, “нууц үг баталгаажуулах” /өөрийн мартахгүй байх нууц үг зохиож үүсгэнэ/ зэрэг талбарыг Монгол хэлээр алдаагүй бөглөж, “үйлчилгээний нөхцөл” хэсгийг чагталсны дараа БҮРТГҮҮЛЭХ товчийг дарж бүртгүүлнэ.
3. НЭВТРЭХ товчлуур дарж нэвтрэх нэр хэсэгт өөрийн регистрийн дугаар, нууц үг хэсэгт өөрийн зохиосон нууц үгийг бичиж системд нэвтрэн орно.
4. Баруун дээд хэсэгт байх өөрийн нэр дээр дарж “Миний мэдээлэл” хэсгийг сонгож нээнэ.
5. Нууц үгээ мартсан бол нууц үгээ сэргээж авна.
6. Таны ашиглаж буй майл хаяг програмд бүртгэлтэй хаягаас зөрж байвал, өөрийн одоо ашиглаж буй и-майлээс credit@hdc.gov.m и-майл-д Нууц үг сэргээх гээд хувийн мэдээллээ бүрэн явуулна уу. / Регистр, Ургийн овог, Утасны дугаар, Оршин суух Аймаг, хот, Сум, дүүрэг, Баг, хороо, Гэрийн хаяг/. Хэрэв та ажлын туршлагаа бөглөсөн бол хүний нөөцөөсөө тусламж авах боломжтой.
7. Майл солигдсон хариу ирсний дараа та өөрөө нууц үгээ сэргээж авна.
8. Таны ажлын туршлагыг танай ажил олгогч байгууллагын хүний нөөц баталгаажуулах үүрэгтэй.
9. Уг бүртгэл нь зөвхөн нэг удаа үүсгэх бөгөөд цаашид өөрчлөлтийн мэдээллээ оруулаад явна.

# Хэрэглэгч - Нууц үгээ мартсан, Нууц үг сэргээх




hr.hdc.gov.mn

Системд нэвтэрч чадаагүй бол **Зураг 1-т** харуулсан Анхааруулга харагдана.
-Та нэвтрэх нэр (регистрийн дугаар), нууц үгээ шалгаад дахин оролдоно уу.

Регистрийн үсгийг крилл үсгээр бичсэн байна.

Таны зохиосон нууц үг

Та нууц үгээ мартсан бол **"Нууц үг сэргээх"** товч дарж регистр, и-мэйл хаяг оруулж и-мэйлээр шинэ нууц үгээ авна уу







Амжилтгүй бол

**Үүнийг унш**

YAHOO тус програмтай хамтран ажиллахгүй байгаа тул Yahoo хаягнаас бусад өөрийн солиулах и-майл хаягнаас credit@hdc.gov.mn хаягт өөрийн Овог, Нэр, Регистр, Утас, И-мэйл, Ургийн овог, Оршин суугаа Аймаг/хот/, Сум/дүүрэг/, Баг/хороо/, Хаягаа илгээн и-майл хаягаа шинэчлүүлэн нууц үгээ өөрөө сэргээж авна.

**зураг2**
1. Регистрийн дугаар:
   Бүртгүүлэхдээ оруулсан таны **регистр**
2. И-мейл хаяг:
   Бүртгүүлэхдээ оруулсан **и-майл** хаяг

**Амжилттай** гэж гарсан бол таны и-майл хаягруу нууц үг илгээгдэнэ. Ирээгүй бол **Spam, Junk, Promotion**-оо шалгана. Мөн и-майлийн санах ой дүүрсэн эсэхийг нягтлана уу.

# Мэргэшлийн зэрэг горилогчийн материал бүрдүүлэх заавар

| МИНИЙ МЭДЭЭЛЭЛ | ТАЙЛБАР |
|---|---|
| ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ<br>/иргэний үнэмлэхийг орлоно/ | • Ургийн овог, Оршин суугаа /**амьдарч байгаа**/, утасны дугаар, майл хаягаа /yahoo хаяг ашиглаж болохгүй/шинэчлэнэ. |
| МЭРГЭЖИЛ | • Мэргэжил, үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшлээ оруулж, дипломын хуулбарыг PDF-ээр хавсаргана.<br>• Хавсралт файл нээгдэхгүй, өөр материал хавсаргасан бол хүсэлтийг хүлээн авахгүй. |
| АЖЛЫН ТУРШЛАГА | • Нийт ажлын туршлагаа өөрөө оруулаад тэр байгууллагын хүний нөөцөөр баталгаажуулна /гарсан туршлагадаа халагдсан огноо тохируулсан бол тухайн хүний нөөц баталгаажуулж чадахгүй тул одоог хүртэл тохиргоотой үлдээгээд хэлж баталгаажуулаад хүний нөөц халагдсан огноог тохируулж өгнө/.<br>• Хүний нөөцөд ажилтан баталгаажуулах зааврыг Тусламж - Хүний нөөцийн зааврааc уншуулаарай.<br>• Хавсралт хэсэгт томилсон тушаал, НД дэвтрийн тушаалын хэсгийн хуулбарыг заавал оруулна. |
| БОЛОВСРОЛ | • Боловсролын зэргийн мэдээллүүдийг /Зөвхөн бакалавр, магистр, доктор, г.м/ оруулна.<br>• Энд мэргэжил эзэмшсэн мэдээллээ оруулсан ч Мэргэжил хэсэгт **заавал давхар** оруулна. |
| ЛИЦЕНЗ | • Зэрэг горилох чиглэлд нийцсэн **хүчинтэй** буюу хүлээн авсан төлөвтэй тусгай зөвшөөрөлтэй байна.<br>• Лиценз шалгах дээр дарахад хүчинтэй лиценз татагдахгүй бол credit@hdc.gov.mn и-майл хаягт овог, нэр, регистр, хүчинтэй лицензийн зургийг илгээнэ. Бид шалгаад хариу өгнө. |
| ЗЭРЭГ | • Зэрэгтэй бол зэргийн мэдээллийг оруулж, гэрчилгээний хуулбарыг **хавсаргана** /зэрэггүйд хамаарахгүй/.<br>• Таны мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлийг хариуцан ажиллах Мэргэжлийн нийгэмлэг, Холбоо, Мэргэжлийн салбар зөвлөлд гишүүнчлэл үүсгэнэ. |
| СУРГАЛТ | • Жил бүрийн багц цаг бүрдсэн байна. Түүний 2/3 нь горилсон мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байна<br>• Сургалт хэсэгт зөвхөн 2019 оны багц цагийн цаасан гэрчилгээг хавсаргана /2020-2022.6 сар хүртэл багц цаг тооцохгүй, 2022.6 сараас хойш багц цаг цахимжсан/. |
| ДҮЙЦҮҮЛЭХ МАТЕРИАЛ | • Хүсэлтийн төрөлд **Зөвхөн** Мэргэжлийн зэрэг сонголтод материал хавсаргана.<br>• Д4. **Тайлбар хэсэгт** тухайн Тусгай шалгуурын дугаар, товч утгыг /1. Зөвлөмж, 2. Судалгааны илтгэл г.м/ бичиж тус тусад нь оруулна. Эхний нүүрэндээ нотлох баримтын **жагсаалттай ГАНЦ** pdf. файл хавсаргана. |

# Нийтлэг шаардлага

| № | Нийтлэг шаардлага | Ахлах | Тэргүүлэх | Зөвлөх | Миний мэдээлэлд хаана хавсаргах |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хувийн мэдээлэл, цээж зураг. | + | + | + | Ерөнхий мэдээлэл |
| 2 | Мэргэшлийн зэрэг горилсон хувийн өргөдөл | + | + | + | Дүйцүүлэх Д1 |
| 3 | Горилсон чиглэлд нэр дэвшүүлж, ёс зүй, мэргэжлийн алдаагүй ажилласан тухай байгууллагын тодорхойлолт | + | + | + | Зэрэг |
| 4 | Мэргэшлийн зэрэг горилсон чиглэлийн мэргэжил, мэргэшлийн диплом, гэрчилгээ авсан огноо | 2017 | 2012 | 2000 | Мэргэжил |
| 5 | Зэрэг горилсон чиглэлд нийцсэн хүчинтэй буюу хүлээн авсан тусгай зөвшөөрөл /зарим чиглэлд шаардахгүй/ | + | + | + | Лиценз |
| 6 | Жил бүрийн багц цаг бүрдсэн, багц цагийн 2/3 нь зэрэг горилсон мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байна. | + | + | + | Сургалт |
| 7 | Шатлалын дагуу өмнөх мэргэшлийн зэрэг авсан огноо | | 2020 | 2020 | Зэрэг |
| 8 | Мэргэшлийн зэрэг горилсон чиглэлээр тасралтгүй ажилласан жил | 8 | 13 | | Мэргэжил, Ажлын туршлага |
| 9 | Сум, тосгон, өрхийн ЭМТ, сум дундын эмнэлэгт ажиллаж байгаа бол тасралтгүй ажилласан жил<br>Тасралтгүй ажилласан хугацааг тооцохдоо ЭМС-ийн 2019 оны 513 тушаалын 2.7 заалтыг харна уу. | 6 | 10 | | |
| 10 | Мэргэшлийн зэрэг горилсон мэргэшил, үндсэн, төрөлжсөн мэргэшлээр нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд тасралтгүй ажилласан байх | | | 25 жил | Ажлын туршлага |
| 11 | Сувилагчийн хувьд тухайн мэргэжил, төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажилласан байх; | | | 20 жил | |
| 12 | Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын зэрэг горилохыг дэмжсэн тодорхойлолт, албан бичиг | | + | + | Дүйцүүлэх Д3 |
| 13 | Зэрэг горилох чиглэлээр байгууллага болон бүс, орон нутгийн хэмжээнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт жил тутам зохион байгуулах эсвэл оролцож, үр дүнд хүрсэн тухай нотлох баримт | | + | + | Дүйцүүлэх Д3 |
| 14 | Салбарын хөгжил, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудалд хувь нэмэр оруулсан манлайлагч байна | | | + | Дүйцүүлэх Д3 |
| 15 | Тусгай шаардлагыг Тусламж хэсгээс харна уу. | + | + | + | Дүйцүүлэх Д4 |
| 16 | Тайлан хамгаалах материал /Зөвлөх болон шинэчлэн тогтоох ажилтан хамгаалалтын өмнө хавсаргана/ | | + | + | Дүйцүүлэх Д5 |

# Анхааруулга

- Зэрэг горилогч нийтлэг болон тусгай шаардлагын нотлох баримтаа программд оруулсны дараа байгууллагын хурлаар хэлэлцүүлж зэрэг олгохыг дэмжсэн шийдвэр гаргуулна /маягтыг Тусламж хэсгээс татна уу/.
- Байгууллага хариуцсан хүний нөөцийн ажилтан Зэрэг горилогчийн Миний мэдээлэл – Зэрэг хэсэгт нэвтэрч “Зэргийн шалгалтад бүртгүүлэх эрх өгөх эсэх” сонголтыг хийн уг тодорхойлолтыг хавсаргаж зэрэг олгохыг дэмжсэнээ баталгаажуулна.
- **Байгууллага дэмжиж зэргийн хүсэлтийг баталгаажуулаагүй тохиолдолд зэргийн шалгалтад бүртгүүлэх боломжгүй.**

# Тасралтгүй ажилласан хугацаа тооцох

- 2.7 Дор дурдсан үндэслэлийг албан ёсны бичиг баримтаар нотолсон тохиолдолд энэхүү журмын 4.1.2, 4.1.3, 4.2.2, 4.2.3, 4.3.2, 4.3.3-т заасан тасралтгүй ажилласан жилд оруулж тооцно:
- 2.7.7 Төгсөлтийн дараах мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцсан.
- Ажилласан жилийн шаардлагыг 4.1.2, 4.1.3, 4.2.2, 4.2.3, 4.3.2, 4.3.3 заалтаар тусад нь зохицуулсан байгаа бөгөөд тус шаардлагыг хангасан ажилтан ажиллах хугацаандаа 2.7.7-д хамаарах сургалтад хамрагдсан бол сургалтын жилийг хорогдуулалгүй суралцсан хугацааг ажилласан жилд оруулж тооцно гэж ойлгоно.
- Уг заалт нь тасралтгүй ажилласан хугацааг хэрхэн бодох тухай утгатай бөгөөд 4.1.1, 4.2.1, 4.3.1 дах заалтыг үгүйсгэсэн буюу мэргэшил эзэмшсэн эсэхийг хэзээнээс тооцох тухай утга агуулаагүй болно.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны Журам шинэчлэн батлах тухай 513 дугаар тушаалын
I хавсралт Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам

# Тасралтгүй ажилласныг тооцох

2.7.1. Жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй;

2.7.2. Цэргийн жинхэнэ алба хаасан, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон;

2.7.3. Өөрийн болон гэр бүлийн гишүүний биеийн эрүүл мэндийн байдлын улмаас мэргэжлээрээ ажиллахгүйгээр эмчлүүлж, сувилуулсан;

2.7.4. Эмнэлгийн шинжилгээ хийлгэсэн, донор

2.7.5. Гадаад улсад мэргэжил, мэргэшлээр суралцсан, магистр, докторын сургалтад хамрагдсан;

2.7.6. Удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр өөр ажил үүрэг гүйцэтгэсэн, төрийн байгууллагын сонгуульт үүрэг гурван сар хүртэл хугацаагаар гүйцэтгэсэн;

2.7.7. Төгсөлтийн дараах мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцсан.

# Хүчинтэй лицензтэй байх

- Программд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх **хүчинтэй** буюу **хүлээн авсан** төлөвтэй тусгай зөвшөөрөлтэй байна.
- Зэрэг авах чиглэлийн дагуу хүчинтэй лицензтэй, 4.1.2, 4.1.3, 4.2.2, 4.2.3, 4.3.2, 4.3.3 заалтын шаардлага хангасан байна.
- Лиценз шалгах дээр дарахад хүчинтэй лиценз татагдахгүй бол credit@hdc.gov.mn хаягт овог, нэр, регистр, хүчинтэй лицензийн зургыг илгээнэ. Бид шалгаад хариу өгнө.

# Мэргэшлийн зэргийн хугацаа

- 9.4 Мэргэшлийн зэрэг нь дараах хугацаагаар хүчин төгөлдөр байна. Үүнд:
- 9.4.1 ахлах, тэргүүлэх зэрэг анх олгосноос хойш тухайн мэргэжил, мэргэшлээр тасралтгүй ажиллаж байгаа нөхцөлд 10 жил
- 9.4.2 журмын 9.4.1-д заасны дагуу мэргэжил, мэргэшлээр тасралтгүй 10 жил ажилласны дараа 1 удаа тухайн мэргэшлийн зэргийг давтан хамгаалах шаардлагатай бөгөөд амжилттай давтан хамгаалсан нөхцөлд тухайн мэргэжил, мэргэшлээр цаашид тасралтгүй ажиллаж байгаа бүхий л хугацаанд;
- 9.4.3 зөвлөх зэрэг олгосноос хойш тухайн мэргэжил мэргэшлээр тасралтгүй ажиллаж байгаа бүхий л хугацаанд.

# Шалгалтад хамрагдах дараалал



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
1996 оноос

**Төгсөлтийн дараах сургалт, шалгалтын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө**

**2024 он**

**Зөвшөөрлийн шалгалт авах өдөр**

- Шалгалтын бүртгэл: Сар бүрийн эхний 7 хоногийн Даваагаас дараагийн Даваа гариг хүртэл
- Шалгалт авах өдөр: Бүртгэл дууссан 7 хоногийн Лхагва гаригт.

**Төрөлжсөн мэргэшлийн сургалтын хаврын элсэлт**

- Сургалтын бүртгэл III/01-15
- Хүсэлт баталгаажна III/22
- СЭБ-д бүртгүүлэх III/26-29
- Сургалт эхлэх өдөр IV/01

**Мэргэжил дээшлүүлэх сургалтын хаврын элсэлт**

- Сургалтын бүртгэл III/18-29
- Хүсэлт баталгаажна IV/01
- СЭБ-д бүртгүүлэх IV/03-05
- Сургалт эхлэх өдөр IV/08

**Төрөлжсөн мэргэшлийн сургалтын намрын элсэлт**

- Сургалтын бүртгэл IX/02-13
- Хүсэлт баталгаажна IX/23
- СЭБ-д бүртгүүлэх IX/24-30
- Сургалт эхлэх өдөр X/01

**Мэргэжил дээшлүүлэх сургалтын намрын элсэлт**

- Сургалтын бүртгэл IX/16-27
- Хүсэлт баталгаажна X/01
- СЭБ-д бүртгүүлэх X/02-04
- Сургалт эхлэх өдөр X/07

**1-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 |
| 29 | 30 | 31 | | | | |

**2-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 | 4 |
| 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 |
| 26 | 27 | 28 | 29 | | | |

**3-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | 2 | 3 |
| 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 |

**4-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 |
| 29 | 30 | | | | | |

**5-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 |
| 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 |
| 27 | 28 | 29 | 30 | 31 | | |

**6-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1 | 2 |
| 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 |
| 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 |

**7-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 |
| 29 | 30 | 31 | | | | |

**8-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 | 4 |
| 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 |
| 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | |

**9-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 |
| 30 | | | | | | |

**10-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 |
| 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 |
| 28 | 29 | 30 | 31 | | | |

**11-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | 2 | 3 |
| 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | |

**12-р сар**

| Да | Мя | Лх | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 |
| 30 | 31 | | | | | |

**Тасралтгүй сургалт эрхлэх байгууллага:**

- Багц цагийн сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн салбар зөвлөлөөр хянуулан сургалт зохион байгуулахаас 1 сарын өмнө hr.hdc.gov.mn программаар илгээж баталгаажуулах

**Мэргэшлийн зэрэг**

- Материал авах III/1-IV/1
- Хүсэлт баталгаажна IV/2
- Шалгалтын хуваарь гарна IV/12
- Шалгалт авах IV/15-V/10
- Зэргийн хүсэлт илгээгдэнэ V/15

**Үндсэн мэргэшлийн сургалтын элсэлт**

- Шалгалтын бүртгэл VIII/16-IX/06
- Шалгалт авах өдөр IX/14,15
- СЭБ сонгох IX/18-20
- СЭБ-д бүртгүүлэх IX/25-27
- Сургалт эхлэх өдөр X/01

Нэрийн тайлал
СЭБ-Сургалт эрхлэх байгууллага

- Мэргэшлийн зэрэг горилогч нь Хүчинтэй хугацаатай лицензтэй, Нийтлэг, Тусгай шалгуурын шаардлага хангасан байна.
- ЗЭРЭГ цэс рүү орж шалгалт өгөх Мэргэжлийн Нийгэмлэг, Холбоо, Салбар зөвлөлийг сонгоно. Жишээ нь: Мэдрэл судлалаар шалгалт өгөх бол Монголын неврологийн нийгэмлэгийг сонгож гишүүнчлэл үүсгэнэ.
- Мэргэжлийн зэргийн шалгалтыг Мэргэжлийн нийгэмлэг, Холбоо, Салбар зөвлөл **бүрэн хариуцах** тул тухайн байгууллагын цахим хуудас, сошиал хуудаст тавигдсан зар мэдээ, зааварчилгаатай тогтмол танилцаж, сошиал хаяг, утсаар нь мэдээллээ тодруулаарай /Холбоо барих мэдээллийг Тусламж хэсгээс харна уу/.
- Шалгалтад бүртгүүлэхийн өмнө Мэргэшлийн зэргийн нийтлэг, тусгай шаардлагын дагуу “Ерөнхий мэдээлэл”, “Мэргэжил”, “Ажлын туршлага”, “Боловсрол”, “Мэргэжлийн зэрэг”, “Сургалт”, “Дүйцүүлэх материал” хэсгийг бүрэн бөглөнө.
- Горилогч дүйцүүлэх материалд **зөвхөн** “Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт” хэсэгт материал хавсаргана.

# Шалгалтад хамрагдах дараалал

- Д4. **Тайлбар хэсэгт** тухайн Тусгай шалгуурын дугаар, товч утгыг /1. Зөвлөмж, 2. Судалгааны илтгэл г.м/ бичиж тус тусад нь оруулна. Эхний нүүрэндээ нотлох баримтын **жагсаалттай ГАНЦ** pdf. файл хавсаргана.
- PDF файлыг Microsoft Word.doc файлд тухайн шалгуурын нотлох баримтын жагсаалт, нотлох баримтаа оруулаад File - Save as - Save as type - PDF – Save гэж үүсгэнэ. Энэ зарчмаар PowerPoint файлаас PDF үүсгэж болно.
- Байгууллагын хурлаар хэлэлцэж зэрэг олгохыг дэмжсэн шийдвэрээ авна /маягтыг Тусламж хэсгээс татна уу/.
- Байгууллага хариуцсан хүний нөөц Зэрэг горилогчийн Миний мэдээлэл – Зэрэг хэсэгт нэвтэрч “Зэргийн шалгалтад бүртгүүлэх эрх өгөх эсэх” сонголтыг хийн уг тодорхойлолтыг хавсаргаж зэрэг олгохыг дэмжсэнээ баталгаажуулна.
- ЗАРЛАЛ - ШАЛГАЛТЫН ЗАР цэсээс горилох мэргэшлийн чиглэл, шатлал, төрлийг зөв сонгон шалгалтад бүртгүүлнэ.
- Шалгалтын хүсэлтийг 3 хоногт баталгаажуулна. Илгээмж хэсэгт татгалзсан хариу ирсэн дариу тайлбарын дагуу засвар хийн, нэмэлт материалаа хавсарган, хүсэлт дахин илгээнэ. Шаардлага хангаагүй бол дахин илгээхгүй.
- Мэргэжлийн нийгэмлэг, Холбоо, МСЗ **2025.09.26**-д хүсэлтийг баталгаажуулаагүй бол шалгалтад оруулахгүй.
- Миний мэдээлэл – Шалгалт хэсэгт онол /системийн/, дадлага /системийн бус/ шалгалтын дүнг харна. Онолын шалгалт **80-аас доош** оноо авсан бол дадлага шалгалтад орохгүй.
- Тайлан хамгаалалтад орох ажилтнууд хамгаалалтын өмнө Дүйцүүлэх Д5 асуумжид материалаа хавсаргана.
- Онол, дадлага шалгалтын дүн Миний мэдээлэл – Шалгалт хэсэгт 2025.10.29-ны дотор бүрэн орсон байх ёстой.
- Мэргэжлийн Нийгэмлэг, Холбоо, Салбар зөвлөл 1. Материалын шаардлага хангасан, 2. Онол, 3. Дадлага шалгалтдаа тэнцсэн ажилтны хүсэлтийг таны өмнөөс **2025.10.29**-д ЭМХТ-д илгээх тул шийдвэрлэх явцтай Миний мэдээлэл – Зэрэг хэсгээс танилцаарай.
- Тогтоосон хугацаанд Шалгалтын хүсэлтийг **хүлээн аваагүй,** онол, дадлагын **дүн оруулаагүй,** Мэргэшлийн зэргийн хүсэлтийг тань **илгээгээгүй** бол Мэргэжлийн Нийгэмлэг, Холбоо, Салбар зөвлөлд хандан тайлбар авна. Ачаалалтай ихтэй ажиллаж буйг ойлгоорой.
- Онол, дадлага шалгалтын нийлбэр дүн **80-аас бага** бол хүсэлтийг илгээхгүй.
- ЭМС-ын тушаал гарсны дараа зэрэг хамгаалсан цахим гэрчилгээг Миний мэдээлэл – Зэрэг хэсгээс авна.

# Миний мэдээлэл – Мэргэжил | мэргэжил нэмэх




**1.** Мэргэжил:
➕ товч дараад **Зураг2**-т харуулсан цонх нээгдэх ба харгалзах утгуудыг бөглөж, сонгоод Хадгалах дарснаар мэргэжил нэмэгдэнэ.




**Хавсаргасан диплом нээгдэж буй эсэхийг шалгаарай**

2. **Мэргэжил:** Эзэмшсэн мэргэжлээ сонгох
3. Тушаалын дугаар : Тушаалын дугаар оруулах /*заавал биш*/
4. Тушаалын огноо: Захирлын тушаал гарсан огноог оруулах
5. Зардлын хэлбэр: Хувийн | Улсын | Төсөл, хөтөлбөрийн гэсэн сонголтоос сонгох
6. Суралцсан улс: Мэргэжил эзэмшсэн улсаа сонгох.
7. Байгууллага: Байгууллага сонгох /хэрэв гадаадад мэргэжил эзэмшсэн бол бичиж оруулах боломжтой./
8. Хавсралт: Таны мэргэжлийн зэргийг нотлох хуулбар баримтыг PDF-ээр оруулах.

дээрх мэдээллүүдийг оруулснаар **Хадгалах** товч дарснаар таны мэдээлэл хадгалагдана.

# Миний мэдээлэл- Ажлын туршлага







1. Байгууллага
2. Алба, тасаг
3. Албан тушаал
4. Ажиллаж эхэлсэн огноо
5. Ажлаас гарсан огноо- хэрвээ одоог хүртэл ажиллаж байгаа бол энэ талбарыг бөглөх шаардлагагүй
6. Хавсралт - ажилд орсон болон ажлаас гарсан тушаал, нийгмийн даатгалын дэвтрийн тушаал-ын хэсгийг хавсаргах

Таны ажлын туршлагыг байгууллага хариуцсан ажилтан баталгаажуулах ёстой. Програмын Тусламж хэсгээс **Хүний нөөцийн заавартай** танилцуулаарай

# Миний мэдээлэл- Боловсрол







1. Суралцсан улс- төгссөн улсын нэр
2. Сургуулийн нэр- төгссөн сургуулийн нэр
3. Мэргэжил- эзэмшсэн мэргэжил /Хүний их эмч, шүдний их эмч, сувилагч г.мэт/
4. Зэрэг- Боловсролын зэрэг /Бакалавр, магистр, доктор г.мэт/
5. Дипломны дугаар
6. Элссэн огноо
7. Төгссөн огноо
8. Хамгаалсан сэдэв
9. Хавсралт- хавсралтаар дипломны хуулбарыг оруулна

Энд боловсролын зэрэг цол оруулна. Мэргэжлээ энд оруулсан ч Мэргэжил хэсэгт **давхар** оруулна

# Миний мэдээлэл- Зэрэг

Системийн бус зэрэг цэсэнд өмнө авсан буюу одоо эзэмшиж байгаа Мэргэшлийн зэргийн мэдээллийг оруулна, хэрвээ байхгүй бол оруулах шаардлагагүй
Системийн зэрэг цэсэнд **тус программаар** авсан зэргийн мэдээлэл орно /*Энэ талбарыг зэрэг горилогч өөрөө бөглөх боломжгүй тул орхино*/







- Мэргэжлийн зэргийн төрлөө сонгох Ахлах | Тэргүүлэх | Зөвлөх
- Зэргийн гэрчилгээний дугаарыг бичиж оруулах
- Зэрэг хамгаалсан огноог оруулах
- Зэрэг хамгаалсан чиглэлийг тодорхой бичиж оруулах
- Өөрийн зэрэг хамгаалсан Мэргэжил | Үндсэн мэргэшил | Төрөлжсөн мэргэшилээс сонгох
- **Хавсралтаар зэргийн гэрчилгээний хуулбарыг оруулах**

**Хадгалах** товч дарснаар таны системийн бус зэргийн бүртгэл нэмэгдэх болно.

Өмнөх хамгаалсан зэргийн үнэмлэхээ PDF файл болгон бэлдээд мэдээллээ системийн бус зэрэг хэсэгт хавсаргаарай.

# Миний мэдээлэл – Гишүүнчлэл сонгох










Таны мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлийг хариуцан ажиллах Мэргэжлийн нийгэмлэг, Холбоо, Мэргэжлийн салбар зөвлөлд гишүүнчлэл үүсгэнэ. Зэрэг олгох **ГАНЦХАН** байгууллагыг сонгоно.
**Ганцхан байгууллага шүү.**

Мэргэжлийн Нийгэмлэг/ Холбоо/ Салбар зөвлөлийн нэр сонгох дарснаар таны зэрэг хамгаалах үйл ажиллагаар хариуцах МЭРГЭЖЛИЙН НИЙГЭМЛЭГ, ХОЛБОО, САЛБАР ЗӨВЛӨЛ түүнд хамаарах мэргэжлүүд бүхий жагсаалт нээгдэнэ. Та өөрийн хамгаалах чиглэлийн дагуу байгууллагаа сонгоод **Хадгалах** дарснаар таны гишүүнчлэл нэмэгдэнэ. **ГИШҮҮНЧЛЭЛ-ээ бөглөөгүй тохиолдолд Нийгэмлэг/Холбоо/МСЗ таны хүсэлтийг ХАРАХ БОЛОМЖГҮЙ.**

# **Миний мэдээлэл -** Дүйцүүлэх материал оруулах




**Тайлбар хэсэгт** тухайн Тусгай шалгуурын дугаар, товч утгыг /1. Зөвлөмж, 2. Судалгааны илтгэл г.м/ бичиж тус тусад нь оруулна.

**Алхам 3.**

**1.** [+] товч дарахад дүйцүүлэх материал оруулах **Зураг 2**-т харуулсан цонх нээгдэнэ.

**2.** Материалын нэр: сонголтыг даран **Зураг 3**-т харуулсан цонх нээгдэхэд **зөвхөн** "Д1-Д4" дугаартай "Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт" хэсэгт материал хавсаргана

**3.** Тайлбар хэсэгт: тухайн Тусгай шалгуурын дугаар, товч утгыг /1. Зөвлөмж, 2. Судалгааны илтгэл г.м/ бичиж тус тусад нь оруулна.

**4.** Хамаарах огноо: Тухайн үйл ажиллагаа явагдсан огноог бичнэ.

**5.** Хавсралт: Эхний нүүрэндээ нотлох баримтын жагсаалттай **ГАНЦ** pdf. файл хавсаргана.

Дээрхи мэдээллүүдийг оруулснаар **Хадгалах** товч дарснаар таны мэдээлэл хадгалагдана.

A.ADMIN

Ерөнхий мэдээлэл | Мэргэжил | Ажлын туршлага | Боловсрол | Лиценз | Зэрэг | Сургалт | Гишүүнчлэл | Шалгалт | Дүйцүүлэх материал | НД лавлагаа

| Хамаарах огноо | Материалын нэр | Кредит | Тайлбар | Бүртгэсэн огноо | Хавсралт | |
|---|---|---|---|---|---|---|
| 2024-02-06 | Д1. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Өргөдлийн маягт. Тусламж хэсгээс маягтыг татна уу/ | 0 | Өргөдөл | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д2. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Байгууллагын дэмжсэн тодорхойлолт. Тусламж хэсгээс маягтыг татна уу/ | 0 | Байгууллагын тодорхойлолт | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д3. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Нийтлэг шаардлага (ЭМС 2019-213 тушаалаас харах Тэргүүлэх 4.2.5, 4.2.7, Зөвлөх 4.3.5, 4.3.7, 4.3.10)/ | 0 | АЭМГ тодорхойлолт | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д3. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Нийтлэг шаардлага (ЭМС 2019-213 тушаалаас харах Тэргүүлэх 4.2.5, 4.2.7, Зөвлөх 4.3.5, 4.3.7, 4.3.10)/ | 0 | Мэргэшүүлэх сургалт удирдсан тайлан | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д4. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Тусгай шалгуурыг Тусламж хэсгээс харна уу. Тайлбарт Тусгай шалгуурын дугаар, утгыг бичнэ/ | 0 | 1. Илтгэл | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д4. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Тусгай шалгуурыг Тусламж хэсгээс харна уу. Тайлбарт Тусгай шалгуурын дугаар, утгыг бичнэ/ | 0 | 2. Гарын авлага | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д4. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Тусгай шалгуурыг Тусламж хэсгээс харна уу. Тайлбарт Тусгай шалгуурын дугаар, утгыг бичнэ/ | 0 | 3. Өдөрлөг | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д4. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Тусгай шалгуурыг Тусламж хэсгээс харна уу. Тайлбарт Тусгай шалгуурын дугаар, утгыг бичнэ/ | 0 | 4. Сэтгэл ханамж | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д4. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Тусгай шалгуурыг Тусламж хэсгээс харна уу. Тайлбарт Тусгай шалгуурын дугаар, утгыг бичнэ/ | 0 | 5. Дотоод сургалт | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д4. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Тусгай шалгуурыг Тусламж хэсгээс харна уу. Тайлбарт Тусгай шалгуурын дугаар, утгыг бичнэ/ | 0 | 6. Шинэ санаа | 2024-02-06 | | |
| 2024-02-06 | Д4. Мэргэжлийн зэргийн дүйцүүлэх баримт /Тусгай шалгуурыг Тусламж хэсгээс харна уу. Тайлбарт Тусгай шалгуурын дугаар, утгыг бичнэ/ | 0 | 7. Ажлын үзүүлэлт | 2024-02-06 | | |

**Хүний бага эмчийн тэргүүлэх зэрэг горилох НИЙТЛЭГ шаардлага**

- Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын зэрэг горилохыг дэмжсэн тодоройлолт, албан бичиг
- Зэрэг горилох чиглэлээр байгууллага болон бүс, орон нутгийн хэмжээнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт жил тутам зохион байгуулах эсвэл оролцож, үр дүнд хүрсэн тухай нотлох баримт

**Хүний бага эмчийн тэргүүлэх зэрэг горилох ТУСГАЙ шаардлага**

1. Ахлах зэрэг хамгаалснаас хойш дангаар болон бусад мэргэжилтэнтэй хамтран эрүүл мэндийн чиглэлээр 3-аас доошгүй удаа илтгэл хэлэлцүүлэн ажилдаа дүн шинжилгээ хийж, хамт олноороо хэлэлцүүлсэн байх
2. Ахлах зэрэг хамгаалснаас хойш иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр зөвлөмж, санамж, гарын авлагыг 3-оос доошгүйг боловсруулсан байх
3. Ахлах зэрэг хамгаалснаас хойш Сум, баг, харьяаллын иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, өдөрлөгийг 3-оос доошгүй зохион байгуулж хийсэн байх
4. Хариуцсан сум, баг, харьяаллын иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа
5. Мэргэжил нэгт болон бусад мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан эсвэл оролцсон илтгэл
6. Иргэдэд эрүүл мэндийн тусламжийн чиглэлээр шинэ санаа, оновчтой санал гарган нэвтрүүлсэн байдал
7. Бага эмч нь ажиллах хугацааны сүүлийн 3 жилийн үндсэн ажлын үзүүлэлт

# Дүйцүүлэх материал зөв хавсаргах

# PDF файл бэлтгэх заавар







Эхний нүүрэнд нотлох баримтын **жагсаалтыг** оруулаад бичиг баримт, зураг, тайлан зэрэг нотлох баримтуудаа байршуулаад зааврын дагуу гүйцэтгэхэд цэгцтэй ганцхан PDF файл үүснэ.

# Системийн зэргийн шалгалтанд бүртгүүлэх

E.EMHT7

- Мэдээлэл
- Зарлал
  - Сургалтын зар
  - Шалгалтын зар

| | Шалгалтын нэр | Шалгалтыг үүсгэсэн | Шалгуулагчийн төрөл | Бүртгэл эхлэх | Бүртгэл дуусах | Шалгалтын огноо | Шалгалтын төлбөр |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Дотрын салбар зөвлөл-Ахлах зэргийн шалгалт | Дотрын салбар зөвлөл | Мэргэшлийн зэрэг олгох - Ахлах | 2022-01-31 12:05 | 2022-02-25 00:00 | 2022-04-25 10:00 | 10₮ |

ШАЛГАЛТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | | | |
|---|---|---|---|
| Шалгалтын нэр: | Дотрын салбар зөвлөл-Ахлах зэргийн шалгалт | Зарласан байгууллага: | Дотрын салбар зөвлөл |
| Шалгалтын төрөл: | Мэргэшлийн зэрэг олгох - Ахлах | Шалгалтын үргэлжлэх хугацаа: | 94 |
| Шалгалтын бүртгэл эхлэх хугацаа: | 2022-01-31 12:05 | Шалгалтын төлбөр: | 10 |
| Шалгалтын бүртгэл дуусах хугацаа: | 2022-02-25 00:00 | Шалгалт авах огноо: | 2022-04-25 10:00 |
| Санамж: | Шалгалтад бүртгүүлэхдээ нийтлэг болон тусгай шаарлагыг бүрэн хангасан байх ёстойг анхаарана уу. Нийтлэг болон тусгай шаардлагыг хангаагүй тохиолдолд шалгалтын хүсэлт буцаагдана. | | |

Бүртгүүлэх

"Ерөнхий мэдээлэл", "Мэргэжил", "Ажлын туршлага", "Боловсрол", "Мэргэжлийн зэрэг", "Гишүүнчлэл", "Дүйцүүлэх материал"-ийг нийтлэг тусгай шаардлагын дагуу бөглөөгүй бол **БҮРТГҮҮЛЖ БОЛОХГҮЙ.**

**Алхам: 1**

**Зарлал - Шалгалтын төрөл - Мэргэшлийн зэргийн шалгалт** цэсээр дамжин өөрийн гишүүнчлэлээ бүртгэсэн байгууллагаас зарласан мэргэшлийн зэрэг олгох шалгалтын жагсаалт харагдах ба шалгалтын нэр дээр дарж ерөнхий мэдээлэл цонхруу орно.

**Алхам: 2**

Шалгалтын ерөнхий мэдээлэл хэсгээс шалгалтын бүртгэл эхлэх дуусах хугацаа, шалгалтын үргэлжлэх хугацаа, төлбөр, шалгалт авах огноо, санамж гэх мэт мэдээллүүдийг нягтлаад **бүртгүүлэх** товч дээр дарснаар хүсэлт илгээдэнэ.

Мэргэжлийн Нийгэмлэг, Холбоо, Салбар зөвлөлөөс таны шалгалтын хүсэлттэй танилцаад бүртгэлийг баталгаажуулах, татгалзах /тайлбартай байна/ боломжтой.

**Татгалзсан тайлбартай танилцан /жишээ нь: ажлын туршлага баталгаажаагүй байна/ материалаа нөхөж оруулаад бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө дахин хүсэлт илгээх боломжтой.**

## ШАЛГАЛТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | | | |
|---|---|---|---|
| **Шалгалтын нэр:** | Дотрын салбар зөвлөл-Ахлах зэргийн шалгалт | **Зарласан байгууллага:** | Дотрын салбар зөвлөл |
| **Шалгалтын төрөл:** | Мэргэшлийн зэрэг олгох - Ахлах | **Шалгалтын үргэлжлэх хугацаа:** | 94 |
| **Шалгалтын бүртгэл эхлэх хугацаа:** | 2022-01-31 12:05 | **Шалгалтын төлбөр:** | 10 |
| **Шалгалтын бүртгэл дуусах хугацаа:** | 2022-02-25 00:00 | **Шалгалт авах огноо:** | 2022-04-25 10:00 |
| **Санамж:** | Шалгалтад бүртгүүлэхдээ нийтлэг болон тусгай шаарлагыг бүрэн хангасан байх ёстойг анхаарана уу. Нийтлэг болон тусгай шаардлагыг хангаагүй тохиолдолд шалгалтын хүсэлт буцаагдана. | | |

**Үндсэн мэргэжил:** Яаралтай тусламж судлал

Бүртгүүлэх

**Шалгалтын цаг:** 2025-10-21 10:00

Зэрэг горилох мэргэжлээ сонгоод цагийг сонгож Бүртгүүлэх ногоон товч дээр дарж шалгалтад бүртгүүлнэ.

Шалгалтын цаг бодит цаг биш тул нийгэмлэг холбооны зараас шалгалтын цагаа тодруулаарай.

**Алхам 2. Шалгалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана**

**Шалгалтын нэр-** Ямар нийгэмлэг, холбоо, салбар зөвлөлөөс шалгалт зарлаж байгаа болон ямар чиглэлийн шалгалт авах талаарх мэдээлэл харагдана
**Шалгалтын төрөл:** Мэргэшлийн зэргийн шалгалт- шатлал /Ахлах, Тэргүүлэх/
**Шалгалтын бүртгэл эхлэх хугацаа:** шалгалтын бүртгэл эхэлсэн огноо
**Шалгалтын бүртгэл дуусах хугацаа:** шалгалтын бүртгэл дуусах огноог анхааралтай харна
**Зарласан байгууллага:** Тус онд мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулах эрх бүхий мэргэжлийн нийгэмлэг, холбоо, салбар зөвлөлийн нэр
**Шалгалт авах огноо:** 2022.06.17-2022.06.30-ны дотор аль нэг өдөр шалгалтын өдөр тавигдсан байна

# Шалгалтын хүсэлт баталгаажилт










Шалгалтанд бүртгүүлэх хүсэлт илгээгдсэн бол таны бүртгүүлэх товч солигдсон байна.

**Зэрэг шинэчлэн тогтоох ажилтнууд шалгалтад орох шаардлагагүй.** Бүртгэлээ хийгээд хүсэлт баталгаажсан бол тайлан хамгаалах товоо тухайн нийгэмлэгээс тодруулна.

Мэргэжлийн Нийгэмлэг, Холбоо, Салбар зөвлөлөөс таны шалгалтын хүсэлттэй танилцаад бүртгэлийг баталгаажуулах, татгалзах боломжтой.

**Татгалзсан тайлбартай танилцан /жишээ нь: ажлын туршлага баталгаажаагүй байна/ материалаа нөхөж оруулаад бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө дахин хүсэлт илгээх боломжтой.**




Шалгалтад бүртгүүлэх хүсэлт 2024.04.02-д баталгаажаагүй бол мэргэшлийн зэргийн онолын шалгалтад оруулахгүй



# Шалгалтын зар – Шалгалт өгөх

Шалгалт авах огноо, байршлыг мэргэжлийн Нийгэмлэг/Холбоо/МСЗ-өөр тодруулаарай




## Шалгалт өгөх

Шалгалтын бүртгэл дуусах хугацаа

Шалгалт авах огноо: 2021-07-09 14:51 цагаас байгаа тул шалгалт тухайн цагт эхэлнэ.

**Шалгалт өгөх** – товч дээр дарж шалгалт өгөх хуудсанд шилжинэ.




Шалгалт өгөх дарахад цаг болоогүй бол шалгалтын хуудас нээгдэхгүй ба эхлэх хугацааны мэдээлэл гарна.

Хүсэлт баталгаажсан тохиолдолд

1. Зэрэг шинээр авах, ахиулах бол санамж хэсэг дээрх зааварчлагын дагуу шалгалтад хамрагдана

2. Зэрэг шинэчлэн тогтоох ажилтнууд **ШАЛГАЛТАД ОРОХГҮЙ** тул хүсэлт баталгаажсан бол ЭМС-ын тушаал гарах хүртэл шийдвэрлэлтийн явцтай Миний мэдээлэл – Зэрэг хэсгээс танилцаарай.

# Шалгалтын зар – Шалгалт өгөх




Шалгалт эхлэхэд дараах цонх нээгдсэн байна.

- Хариулт бөглөсөн асуултын дугаар **ногоон** өнгөтэй болно.

- Асуултын харгалзах хариулт дээр дарснаар зурагт харуулсан шиг хариултын өнгө **цэнхэр** болно.

Бүх асуултын хариултыг сонгосон бол Хамгийн дор байрлах **Дуусгах** товч дээр дарж шалгатыг дуусгана.



# Хувийн мэдээлэл – Шалгалтын түүх




Шалгалт өгсөн хэрэглэгч шалгалтын түүх харах бол

Миний мэдээлэл -> Шалгалт цэс дээр дарж **Системийн шалгалт** хуснэгтээс систем дээр өгсөн шалгалтын үр дүн, өгөх шалгалтын мэдээллийг харах боломжтой.

Үүнд :

- Шалгалтын нэр
- Төрөл
- Дэд төрөл
- Авсан оноо
- Босго оноо
- Тэнцсэн эсэх
- Огноо

Зэргийн онол /системийн/, дадлага /системийн бус/ шалгалтын мэдээлэл тань **2024.05.10**-ны дотор Шалгалт цэсэнд хавсрагдсан байх ёстой.

Материалын шаардлага ханган шалгалтад орсон ч онол, дадлага шалгалтад 80-аас доош **хангалтгүй оноо авсан** ажилтанд програмаас ямар нэг мэдэгдэл очихгүй бөгөөд харъяалах нийгэмлэг, холбоо салбар зөвлөлөөс лавлах шаардлагагүй.

# Зэрэг, зэргийн хүсэлт




Материалын шаардлага хангаан шалгалтад орж онол, дадлагын шалгалтад амжилт үзүүлсэн ажилтны Миний мэдээлэл – Зэрэг цэсний ситемийн зэрэг хэсэгт **2024.05.15**-ны өдөр хүсэлт ХҮЛЭЭН АВААГҮЙ төлөвтэй байгаа тохиолдолд харъяалах нийгэмлэг, холбоо салбар зөвлөлөөс лавлаарай. Шалгалтын нийлбэр дүн **80-аас бага** бол та зэрэг горилох боломжгүй тул холбогдох шаардлагагүй.

Шалгалтанд бүртгүүлээд, шалгалтыг амжилттай дүүргэсэн бол Мэргэжлийн нийгэмлэг/ холбоо/ салбар зөвлөлөөс **ТАНЫ ӨМНӨӨС** зэргийн хүсэлтийг ажлын алба буюу ЭМХТ-рүү илгээх болно.

Та /системийн/ зэргийн хүсэлтийн шийдвэрлэлт, хэзээ илгээснийг харах боломжтой.

ЭМС-ын тушаал гарснаар Гэрчилгээний дугаар дээр дарж **Гэрчилгээ**гээ хувилж аваарай.




Та мэргэшлийн зэрэг хамгааллаа



# Заавартай бүрэн танилцсан танд баярлалаа

## ЦАХИМ ПЛАТФОРМ БАТАЛГААЖСАН МЭДЭЭЛЭЛ

- www.hr.hdc.gov.mn